



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.09 № 01/450  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮН  
НАМЫН ХОРООНЫ ДАРГА  
Б.МӨНХБОЛД ТАНАА

### Хандивын тайлангийн дүгнэлт

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Хүн намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн Аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

### Дүгнэлтийн үндэслэл

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Хүн намын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дугаар тушаалаар баталсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

6724041969

**Дүгнэлт**

Хөвсгөл аймгийн Хүн намын хороо нь ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй байна.

Хөвсгөл аймгийн Хүн намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР





Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Төргүүлэх аудиторын 2024 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 01/09/24 дугаартай албан бичгийн хоёр дугаар хавсралт

Маягт №-2

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд "ХУУЛИЙН ЭТГЭЭД"-ээс өгсөн хандивын 05 тайлангийн маягт

Нам, эвслийн нэр: Хөвсгөл аймгийн Хүн намын хороо

/Мян.төг/

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл								Хандив хүлээн авсан	Мөнгөн дүн	АНСДИТХ-н сонгуулийн тухай хуулийн 53.4-т заасан хандивын мэдээллийн шаардлага хангаагүй хандивыг буцаан шилжүүлсэн эсэх				Тайлбар	
		Регистрийн дугаар	Хандивын эх үүсвэрийн мэдээлэл	Хаяг, утасны дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Үйл ажиллагааны чиглэл	Хуулийн этгээдийн хэлбэр	Огноо	Банкны нэр			Дансны дугаар	Тийм бол мөнгөн дүн	Хандивыг буцаасан дансны дугаар	Буцах хаяг тодорхойгүй хандивыг улсын орлого буюу төрийн санд шилжүүлсэн тохиолдолд огноо, дансны дугаар бичих		Хандив аваагүй
1																	
...																	
	Дүн																
2023 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаа																	
1																	
...																	
	Дүн																
	Нийт дүн																
2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаа																	
1																	
...																	
	Дүн																
	Нийт дүн																

--00000--